

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Нийт хандивын орлогын 66.0 хувийг зочид төлөөлөгчдийн гарын бэлэг, хүлээн авалт зэрэг нэг удаагийн шинж чанартай арга хэмжээнд зарцуулсан байна.



АУДИТЫН СЭДЭВ: СУМДЫН 100 ЖИЛИЙН ОЙН ХАНДИВЫН ЗАРЦУУЛАЛТ, ҮР ДҮН
АУДИТЫН КОД: СЭА-2025/44-ШТА-ГА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Сүхбаатар сум
2025.10.20

Дарга, тэргүүлэх аудиторын албан үүргийг түр орлон
гүйцэтгэгч Б.Батмөнх

Утас: 70363036, Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn

Ахлах аудитор С.Баасансүрэн

Утас: 70362442, Цахим хаяг: Baasansurens@audit.gov.com

Аудитор Б.Наранцэцэг

Утас: 70362442, Цахим хаяг: Narantsetsegba@audit.gov.mn

Аудитор Ж.Баясгалан

Утас: 70362442, Цахим хаяг: Bayasgalani@audit.gov.mn

Аудитор Р.Отгонжаргал

Утас: 70362442, Цахим хаяг: Otgonjargalr@audit.gov.mn

Товчилсон үгийн тайлбар	2
Хүснэгтийн товъёг	2
Дүрслэлийн товъёг	2
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл	3
Ерөнхий мэдээлэл	4
1 дүгээр бүлэг: Зарим сумын НҮТББ нь ойн хандивын дансанд төсвийн орлогыг төвлөрүүлж, зарцуулсан байна.	5
1.1 Ихэнх НҮТББ-ууд нь ойн хандивын орлогын төлөвлөгөөг сумын ИТХ-аар батлуулаагүй байна.	5
1.2 Түшиг сумын “Зэлтэр сумын хөгжлийн сан” НҮТББ нь хандивын хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан байна.	8
2 дугаар бүлэг: Сумдын ИТХ, Засаг даргын зүгээс хандивын орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт хэрэгжүүлээгүй, үр дүнг үнэлж, дүгнээгүй байна.	11
2.1 Иргэдэд ээлтэй, хүртээмжтэй, нөлөө үзүүлэхүйц үр дүнтэй ажил зохион байгуулаагүй, бүтээн байгуулалтын ажил хийгдээгүй байна.	11
2.2 Ойн хандивын хүрээнд бий болсон зарим хөрөнгийг бүртгэл тайланд тусгаагүй байна.	13
2.3 Хандивын хөрөнгийн зарцуулалтын үр дүнгийн талаарх мэдээллийг иргэд, олон нийтэд ил тод мэдээлээгүй байна.	14
Илрүүлсэн зөрчил	16
Дүгнэлт	17
Зөвлөмж	17
Ирүүлсэн санал, тайлбар	17

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
ГҮТББ	Гишүүдэд үйлчлэх төрийн бус байгууллага
ЖДҮ	Жижиг дунд үйлдвэр
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НҮТББ	Нийтэд үйлчлэх төрийн бус байгууллага
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан

Хүснэгтийн товьёг

<i>Д/д</i>	<i>Тайлбар</i>	<i>Хуудасны дугаар</i>
<i>Хүснэгт 1</i>	<i>Төрийн бус байгууллагуудын жагсаалт</i>	<i>5</i>
<i>Хүснэгт 2</i>	<i>Хандивын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл</i>	<i>6</i>
<i>Хүснэгт 3</i>	<i>Мөнгөн хандив</i>	<i>6</i>
<i>Хүснэгт 4</i>	<i>Мөнгөн бус хандив</i>	<i>7</i>
<i>Хүснэгт 5</i>	<i>Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажил</i>	<i>12</i>
<i>Хүснэгт 6</i>	<i>Бүртгэл тайланд тусгасан хөрөнгийн жагсаалт</i>	<i>14</i>
<i>Хүснэгт 7</i>	<i>Бүртгэл тайланд тусгаагүй хөрөнгийн жагсаалт</i>	<i>15</i>
<i>Хүснэгт 8</i>	<i>Ажлын хэсэг байгуулсан сумдын ИТХ, Засаг даргын шийдвэр</i>	<i>16</i>
<i>Дүрслэл 1</i>	<i>Хандивын төрөл</i>	<i>7</i>
<i>Дүрслэл 2</i>	<i>Хандивын зарцуулалт</i>	<i>8</i>
<i>Дүрслэл 3</i>	<i>Сумдын малын хандив</i>	<i>10</i>

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, СТАНДАРТЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ

<p>Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:</p>	<p>Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2025 оны “Аудитын сэдэв батлах тухай” А/107 дугаар тушаал, Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын 2025 оны “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г үндэслэн тус газрын дарга, тэргүүлэх аудиторын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.</p>
<p>Аудитын зорилт:</p>	<p>Баруунбүрэн, Ерөө, Зүүнбүрэн, Мандал, Түшиг, Цагааннуур, Шаамар сумдын 100 жилийн ойн хандивын бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад танилцуулахад аудитын зорилт оршлоо. Уг зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэв. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Сумдын ойн хандивыг хууль тогтоомжийн дагуу бүрдүүлж, зарцуулсан уу? • Сумдын ойн хүрээнд төлөвлөсөн арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, үр дүнг үнэлж, тайлагнасан уу?
<p>Аудитын хамарсан хүрээ:</p>	<p>Баруунбүрэн, Ерөө, Зүүнбүрэн, Мандал, Түшиг, Цагааннуур, Шаамар сумдын “Хөгжлийн төлөө зууныг өртөөлөх Бургалтай”, “Бидний бахархалт Ерөө нутаг”, “Мойлт Жаргалант хайрхан”, “Мандал түмний хишиг”, “Нуурын төлөө”, “Зэлтэр нутгийн хөгжлийн сан”, “Шаамарын хөгжил 100 жил” ТББ-ууд болон сумдын ИТХ, Засаг дарга, ЗДТГ зэрэг эрх бүхий байгууллагуудын баримт материалуудыг хамруулан аудитыг хийж гүйцэтгэлээ.</p>
<p>Аудитын арга зүй:</p>	<p>Аудитыг АДБОУС 100, 300, 3000, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, түүнд нэмэлт өөрчлөлт оруулсан 2021 оны А/69 дүгээр тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-ын дагуу гүйцэтгэлээ.</p> <p>Аудитад сумдын ИТХ болон Засаг дарга, НҮТББ-ын холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, харьцуулах, нэгтгэх, баримт, материалд тулгуурлан дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглаж, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулан аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.</p>
<p>Аудитын шалгуур, үзүүлэлт:</p>	<ul style="list-style-type: none"> • Үндэсний их баяр наадмын тухай хууль, • Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, • Төрийн бус байгууллагын тухай хууль,

	<ul style="list-style-type: none"> • Засгийн газрын 2019 оны 204 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх журам”, • Аймгийн ИТХ-ын 2022 оны 37 дугаар тогтоолоор баталсан “Сэлэнгэ аймагт сум, байгууллагын тэгш ой тэмдэглэх зөвшөөрөл олгох журам”, • Аймгийн ИТХ-ын 2023 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 128, 130, 131, 10 дугаар сарын 04-ний өдрийн 134, 135, 136, 137 дугаар тогтоол, • Сумдын ИТХ-ын тогтоол, Засаг даргын захирамж, холбогдох бусад хууль, эрх зүйн актууд.
<p>Аудитын бүрэлдэхүүн, хугацаа:</p>	<p>Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, аудитын менежер Б.Батмөнх удирдаж, явцын болон чанарын хяналтыг гүйцэтгэн, ахлах аудитор С.Баасансүрэн, аудитор Б.Наранцэцэг, Ж.Баясгалан, Р.Отгонжаргал нар 2025 оны 09 дүгээр сарын 19-ний өдрөөс 10 дугаар сарын 20-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэлээ.</p>
<p>Ерөнхий мэдээлэл:</p>	<p>Засгийн газрын 2019 оны 204 дүгээр тогтоолоор баталсан “Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх журам”-ын 2 дугаар хавсралтын 1.6 дахь заалт, аймгийн ИТХ-ын 2022 оны 37 дугаар тогтоолоор баталсан “Сэлэнгэ аймагт сум, байгууллагын хэмжээнд тэгш ой тэмдэглэхэд зөвшөөрөл олгох журам”-ын дагуу аймгийн ИТХ-ын 2023 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 128, 130, 131, 10 дугаар сарын 04-ний өдрийн 134, 135, 136, 137 дугаар тогтоолуудаар дээрх сумдын 100 жилийн ойг 2024 оны 7 дугаар сард тэмдэглэн өнгөрүүлэхийг зөвшөөрсөн байна.</p> <p>Дээрх зөвшөөрлийн дагуу сумдын ИТХ-ын тогтоол болон Засаг даргын захирамжаар сумын 100 жилийн ойг зохион байгуулах “Ажлын хэсэг”-ийг байгуулсан байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Баруунбүрэн сумын ИТХ-ын 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 83 дугаар тогтоолоор 29 хүний бүрэлдэхүүнтэй, • Зүүнбүрэн сумын ИТХ-ын 2024 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор 27 хүний бүрэлдэхүүнтэй, • Мандал сумын ИТХ-ын 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 138 дугаар тогтоолоор 25 хүний бүрэлдэхүүнтэй, • Цагааннуур сумын ИТХ-ын 2024 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 126 дугаар тогтоолоор 17 хүний бүрэлдэхүүнтэй, • Шаамар сумын Засаг даргын 2024 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн А/69 дүгээр захирамжаар 12 хүний бүрэлдэхүүнтэй зэрэг. <p>Ерөө сум (сумын ИТХ-ын 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 134 дүгээр тогтоолоор баталсан) -аас бусад сумд 100 жилийн ойн арга хэмжээ, үндэсний их баяр наадмын төсвийг ИТХ-ын тогтоолоор батлаагүй байна.</p>

Бүлэг 1

Сумдын ойн хандивыг хууль тогтоомжийн дагуу бүрдүүлж, зарцуулсан уу?

Зарим сумын НҮТББ нь ойн хандивын дансанд төсвийн орлогыг төвлөрүүлж, зарцуулсан байна.

1.1 Ойн хандивыг төлөвлөсний дагуу бүрэн бүрдүүлсэн үү?

Ихэнх НҮТББ-ууд нь ойн хандивын орлогын төлөвлөгөөг сумын ИТХ-аар батлуулаагүй байна.

1.1.1. Засгийн газрын 2019 оны 204 дүгээр тогтоол, аймгийн ИТХ-ын 2022 оны 37 дугаар тогтоолыг тус тус үндэслэн аймгийн ИТХ-ын 2023 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 128, 130, 131, 10 дугаар сарын 04-ний өдрийн 134, 135, 136, 137 дугаар тогтоолоор сумын 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх зөвшөөрлийг олгосон байна.

1.1.2. Уг зөвшөөрлийн дагуу Баруунбүрэн, Ерөө, Зүүнбүрэн, Мандал, Түшиг, Шаамар зэрэг 6 сум нь хандивын орлого төвлөрүүлэх зорилго бүхий төрийн бус байгууллагуудыг үүсгэн байгуулсан бол харин Цагааннуур сумын “Нуурын төлөө” НҮТББ нь өмнө үйл ажиллагаа явуулж байсан байна. Үүнийг дараах хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 1. Төрийн бус байгууллагуудын жагсаалт

№	Сумын нэр	Төрийн бус байгууллагын нэр	УБХ-д бүртгүүлсэн огноо	Улсын бүртгэлийн дугаар
1	Баруунбүрэн	Хөгжлийн зууныг өртөөлөх бургалтай	2024.01.29	1371002106
2	Ерөө	Бидний бахархалт Ерөө нутаг	2023.09.21	1371002092
3	Зүүнбүрэн	Мойлт Жаргалант хайрхан	2024.01.08	1371002098
4	Мандал	Мандал Түмний хишиг	2024.01.17	1371002103
5	Түшиг	Зэлтэр нутгийн хөгжлийн сан	2023.10.02	1371002093
6	Цагааннуур	Нуурын төлөө	2014.01.03	1371001028
7	Шаамар	Шаамарын хөгжил 100 жил	2024.02.29	1371002109

1.1.3. Засгийн газрын 2019 оны 204 дүгээр тогтоолын 2.3-т “Тэмдэглэлт өдрийг тэмдэглэх асуудлыг тухайн байгууллага үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөвтөө тусган батлуулж, зардлын гүйцэтгэлд нь хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллана” гэж заасан байдаг.

1.1.4. Ерөө сумын ИТХ-ын 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 134 дүгээр тогтоолоор 100 жилийн ойн хандивын орлогын төлөвлөгөөг боловсруулж, батлуулсан байна.

Харин Баруунбүрэн, Зүүнбүрэн сумд нь 100 жилийн ойн хандивын орлогын төлөвлөгөөг ИТХ-аар батлуулаагүй боловч ой зохион байгуулах “Ажлын хэсэг” нь орлогын тооцоо, төлөвлөгөөг хийсэн байна.

Мандал сумын “Мандал түмний хишиг” НҮТББ нь хэрэгжүүлэх арга хэмжээний орлогын тооцоо, төсвийг хийсэн бол Түшиг, Цагааннуур сум нь хандивын орлогын төлөвлөгөөг боловсруулаагүй байна.

Сумдын 100 жилийн ойн хандивын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг дараах хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 2. Хандивын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

/Мянган төгрөгөөр/

№	Сумын нэр	Төрийн бус байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Баруунбүрэн	Хөгжлийн зууныг өртөөлөх бургалтай	877,887.0	469,870.1
2	Ерөө	Бидний бахархалт Ерөө нутаг	1,300,000.0	1,124,906.3
3	Зүүнбүрэн	Мойлт Жаргалант хайрхан	717,261.0	505,930.9
4	Мандал	Мандал Түмний хишиг	-	781,134.0
5	Түшиг	Зэлтэр нутгийн хөгжлийн сан	-	573,709.3
6	Цагааннуур	Нуурын төлөө	-	728,270.0
7	Шаамар	Шаамарын хөгжил 100 жил	-	303,347.9

Дээрх хүснэгтээс үзэхэд 100 жилийн ойн хандивын орлогыг Ерөө сум нь 1,300,000.0 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 1,124,906.3 мянган төгрөгийг, Зүүнбүрэн сум нь 717,261.0 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 505,930.9 мянган төгрөгийг, Баруунбүрэн сум нь 877,887.0 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 469,870.1 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Харин Мандал, Түшиг, Цагааннуур, Шаамар сумд хандивын орлогыг төлөвлөж, ИТХ-аар батлуулалгүйгээр 303,347.9-781,134.0 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байна.

1.1.5. 100 жилийн ой тохиосон дээрх 7 сум нь төрийн бус байгууллагын дансанд иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудаас нийт **4,487,168.5** мянган төгрөгийн мөнгөн хандивыг төвлөрүүлсэн байна. Үүнийг дараах хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 3. Мөнгөн хандив

/Мянган төгрөгөөр/

№	Сумын нэр	Мөнгөн хандив						
		Иргэн	ААНБ	Төр, төсвийн байгууллагууд /цалингаас/	ЖДҮ, худалдаа эрхлэгчид	ОНХС	Хүүгийн орлого	Нийт дүн
1	Баруунбүрэн	288,720.1	129,120.0	52,030.0	-	-	-	469,870.1
2	Ерөө	259,295.7	820,317.2	27,946.1	15,300.0	-	2,047.4	1,124,906.3
3	Зүүнбүрэн	211,757.3	225,579.7	14,213.0	2,500.0	51,880.9	-	505,930.9
4	Мандал	72,330.0	477,392.6	189,301.8	27,535.0	14,574.6	-	781,134.0
5	Түшиг	188,263.3	378,580.0	5,866.0	1,000.0	-	-	573,709.3
6	Цагааннуур	395,720.0	322,800.0	9,750.0	-	-	-	728,270.0
7	Шаамар	215,500.0	62,500.0	18,100.0	7,200.0	-	47.9	303,347.9
	Нийт дүн	1,631,586.4	2,416,289.5	317,206.9	53,535.0	66,455.5	2,095.3	4,487,168.5

Дээрх хүснэгтээс үзэхэд нийт мөнгөн хандивын 53.8 хувийг аж ахуйн нэгж байгууллагуудаас, 36.4 хувийг иргэдээс, 7.1 хувийг төр, төсвийн байгууллагуудын албан хаагчдын цалингаас, 1.5 хувийг ОНХС-ийн санхүүжилтээс, 1.2 хувийг ЖДҮ, худалдаа эрхлэгчдээс, 0.05 хувийг хүүгийн орлого эзэлж байна.

1.1.6. Иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудаас нийт **943,697.3** мянган төгрөгийн мөнгөн бус хандив төвлөрүүлсэн бөгөөд үүнийг дараах хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 4. Мөнгөн бус хандив

/Мянган төгрөгөөр/

№	Сумын нэр	Мөнгөн бус хандив			
		Үндсэн хөрөнгө	Бараа материал	Бусад	Нийт дүн
1	Баруунбүрэн	244,459.3	-	129,570.0	374,029.3
2	Ерөө	20,000.0	20,097.2	-	40,097.2
3	Зүүнбүрэн	-	1,800.0	-	1,800.0
4	Мандал	249,480.0	68,640.0	22,500.0	340,620.0
5	Түшиг	-	-	-	-
6	Цагааннуур	2000.0	17,200.0	80,259.0	117,659.0
7	Шаамар	69,491.8	-	-	69,491.8
Нийт дүн		603,631.1	107,737.2	232,329.0	943,697.3

Дээрхээс үзэхэд нийт мөнгөн бус хандивын 63.9 хувь нь үндсэн хөрөнгө, 24.6 хувь нь бусад мөнгөн бус хандив, 11.4 хувь нь бараа материал эзэлж байна.

1.1.8. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудаас нийт 5,430,865.8 мянган төгрөгийн мөнгөн болон мөнгөн бус хандив төвлөрсөн бөгөөд сум тус бүрээр хандивын хэмжээ болон хэлбэрээр ангилан дараах дүрслэлээр харуулбал:

Дүрслэл 1. Хандивын орлогын төрөл.

/мянган төгрөгөөр/



1.1.9. Баруунбүрэн, Түшиг сумын НҮТББ -ууд нь төсвийн орлого болох нийт 44,630.0 мянган төгрөгийг хандивын дансанд төвлөрүүлж, сумын 100 жилийн ойн арга хэмжээнд зарцуулсан байна. Үүнд:

- Баруунбүрэн сум нь Орхон аймгийн Жаргалант сумын ЗДТГ-аас бэлчээрийн менежментийг сайжруулах хамтын ажиллагааны зориулалтаар шилжүүлсэн 30,000.0 мянган төгрөгийг,
- Түшиг сум нь хууль бусаар бэлтгэж, хураагдсан модыг худалдан борлуулсны төлбөр болох 14,630.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8 дахь “Сум, дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны төсвийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ”: 23.8.6-д “Байгалийн ургамал ашигласны төлбөр”, 23.9.3-т “хууль тогтоомжийн дагуу сум, дүүргийн төсөвт орох бусад орлого” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

1.1.10. Дээрхээс дүгнэхэд ихэнх сумд нь 100 жилийн ойн хандивын орлогыг төлөвлөгөөгүй, эрх бүхий байгууллагаар батлуулаагүйгээс шалтгаалан хандивын орлого бүрэн төвлөрүүлээгүй байна.

1.2 Хандивын хөрөнгийг хууль тогтоомжийн хүрээнд зориулалтын дагуу зарцуулсан уу?

Түшиг сумын “Зэлтэр сумын хөгжлийн сан” НҮТББ нь хандивын хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

1.2.1. Засгийн газрын 2019 оны 204 дүгээр тогтоолоор баталсан “Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх журам”-ын 2.3-т “Тэмдэглэлт өдрийг тэмдэглэх асуудлыг тухайн байгууллага үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөвтөө тусган батлуулж, зардлын гүйцэтгэлд нь хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллана” гэж заасан байдаг.

1.2.2. Сумд нь 100 жилийн ойн арга хэмжээнд нийт 4,487,168.5 мянган төгрөгийн хандивын орлогыг төвлөрүүлж, 4,284,566.4 мянган төгрөгийг зарцуулсан байна /дэлгэрэнгүйг хавсралт 1-д харуулав/. Үүнийг дараах дүрслэлээр харуулбал:

Дүрслэл 2. Хандивын зарцуулалт.

/Мянган төгрөгөөр/




Дээрхээс үзэхэд нийт зардлын 35.1 хувийг хүлээн авалт, 1 удаагийн арга хэмжээ, 20.6 хувийг уралдаан, тэмцээн, шагнал, урамшуулалд, 11.0 хувийг сонин, хэвлэл мэдээлэл, сурталчилгаанд, 10.3 хувийг гарын бэлэг, дурсгалд, 6.3 хувийг хөрөнгө оруулалтын шинж чанартай бүтээн байгуулалтын ажилд, 5.7 хувийг урсгал зардалд, 5.1 хувийг бараа материал худалдан авахад, 2.5 хувийг үндсэн хөрөнгө худалдан авахад, 1.7 хувийг цалин, НДШ, татварт, 1.7 хувийг бусад зардалд зарцуулсан байна.

1.2.3. Баруунбүрэн, Ерөө, Мандал, Түшиг, Цагааннуур сумд нь мөнгөн болон мөнгөн бус хандиваас гадна үнэлэгдэх боломжгүй адуу, үхэр, хонь, ямаа зэрэг нийт 116 толгой мал болон цагаан идээ, зөгийн бал зэрэг хүнсний бүтээгдэхүүнийг хандиваар хүлээн авч, зочид төлөөлөгчдийн хүлээн авалт, хоол хүнс, бай шагналд зарцуулсан байна. Үүнийг дараах дүрслэлээр харуулбал:

Дүрслэл 3. Сумдын малын хандив.

/Тоо ширхгээр/



- Баруунбүрэн сум нь хандиваар ирсэн 1 хурдан удмын даагыг аймгийн начин А.Амархүүгийн цолны мялаалгад бэлэглэсэн бол бусад 19 толгой малыг хүлээн авалтын хоол хүнсэнд,
- Ерөө сум нь 11 толгой малыг хүлээн авалтын хүнсэнд, цагаан идээг наадмын төв асарт таваг засахад,
- Мандал сум нь хандиваар ирсэн 5 даагыг бай шагналд, 49 толгой малыг хүлээн авалтын хоол хүнсэнд, цагаан идээг наадмын төв асарт таваг засахад,
- Түшиг сум нь хандиваар ирсэн 17 толгой малыг наадмаар ажилласан цагдаагийн албан хаагчдын болон зочид төлөөлөгчид, хүлээн авалтын хоол хүнсэнд,
- Цагааннуур сум нь 11 толгой малыг зочид төлөөлөгчдийн хоол хүнсэнд хэрэглэсэн бол 1 үхэр, 2 хонийг 2025 оны хавар гарсан түймрийн голомтод ажилласан албан хаагчдын хоол хүнсэнд зарцуулсан байна.

1.2.4. 100 жилийн ойн арга хэмжээг зохион байгуулах чиг үүрэгтэй Түшиг сумын “Зэлтэр нутгийн хөгжлийн сан” НҮТББ-ын даргаар тус сумын Засаг даргын орлогч Ц.Мөнхсайхан, Шаамар сумын “Шаамарын хөгжил 100 жил” НҮТББ-ын гишүүнээр тус сумын Засаг дарга Ф.Серикбол нар ажиллаж, ойн арга хэмжээний хандивын орлого, зарлагыг захиран зарцуулах үйл ажиллагаанд биечлэн оролцсон байна.

Энэ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.11 дэх “Ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал”, 18 дугаар зүйлийн 18.1 дэх “Давхар ажил, албан тушаал эрхлэхийг хориглох”, 27 дугаар зүйлийн 27.2 дахь “Ёс зүйн шалтгаанаар эргэлзээ төрвөл албан үүргээс татгалзах үүрэг” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

1.2.5. Зэлтэр нутгийн хөгжлийн сан НҮТББ нь сумын 100 жилийн ойн хүрээнд төвлөрүүлсэн хандивын хөрөнгөнөөс 13,000.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна. Үүнийг тодруулбал:

- *Сумын Засаг дарга Н.Батболд болон малчдын төлөөллийн хамт БНХАУ-д туршлага судлах, сургалтад хамрагдах аяллаар явах зардалд 10,000.0 мянган төгрөг,*
- *Цагдаагийн байгууллага үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойд зориулж 3,000.0 мянган төгрөгийг хандивласан байна.*

Энэ нь Төрийн бус байгууллагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх “Төрийн бус байгууллага нь орлогоо зөвхөн дүрэмд заасан зорилгоо хэрэгжүүлэх үйл ажиллагаанд зарцуулна” гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.2.6. Шаамар сумын 100 жилийн ойн хүрээнд байгуулагдсан “Шаамарын хөгжил 100 жил” НҮТББ нь хандивын дансны хуулганаас бусад орлого, зарлагын анхан шатны баримт материалыг аудитын явцад ирүүлээгүй болно.

1.2.7. Сумын 100 жилийн ойн хүрээнд байгуулагдсан НҮТББ-ын хандивын данс нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 202,602.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан бол 2025 онд нийт 37,664.4 мянган төгрөгийн дараах гүйлгээнүүд хийгдсэн байна. Үүнийг тодруулбал:

Баруунбүрэн:

- *Татварт 684.4 мянган төгрөг,*
- *Бараа материалын зардалд 640.0 мянган төгрөг.*

Ерөө:

- *Тракторын моторын үнэ 8,500.0 мянган төгрөг,*
- *НҮТББ-ын дарга, нягтлан бодогчийн цалинд 6,527.6 мянган төгрөг,*
- *“Майкрофт аудит” ХХК-д аудитын төлбөрт 1,000.0 мянган төгрөг.*

Түшиг:

- *Шатахууны зардалд 462.4 мянган төгрөг.*

Цагааннуур:

- *Сумын алтан гадас одонгийн шагналын арга хэмжээнд 13,350.0 мянган төгрөг.*

Шаамар:

- *Цэнгэлдэх хүрээлэнгийн нойлын үлдэгдэл ажлын хөлсөнд 450.0 мянган төгрөг гэх мэт.*

1.2.8. Ерөө, Зүүнбүрэн, Мандал, Цагааннуур сумын НҮТББ-аас бусад нь 2024 оны санхүүгийн тайлан гаргаагүй байна. Энэ нь Төрийн бус байгууллагын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх “Төрийн бус байгууллага нь зохих журмын дагуу жилийнхээ тайлан тэнцлийг гаргаж дараа оны 2 дугаар сарын 15-ны дотор Татварын албанд өгнө” гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.2.9. Дээрхээс үзэхэд 100 жилийн ойн хандивын орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад сумын эрх бүхий байгууллагын зүгээс тавих хяналт сул, зарим төрийн бус байгууллагууд санхүүгийн тайлан гаргаагүй, хувь хүний болон нийтийн ашиг сонирхлын зөрчил үүсгэсэн зэрэг нь Төрийн бус байгууллагын тухай болон нийтийн албанд хамаарах хуулийн заалтыг зөрчих үндсэн шалтгаан болсон байна.

Бүлэг 2

Сумдын ойн хүрээнд төлөвлөсөн арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, үр дүнг үнэлж, тайлагнасан уу?

Сумдын ИТХ, Засаг даргын зүгээс хандивын орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт хэрэгжүүлээгүй, үр дүнг үнэлж, дүгнээгүй байна.

2.1 Хандивын хөрөнгөөр сум, орон нутагт шаардлагатай бүтээлч ажил зохион байгуулсан уу?

Иргэдэд ээлтэй, хүртээмжтэй, нөлөө үзүүлэхүйц үр дүнтэй ажил зохион байгуулаагүй, бүтээн байгуулалтын ажил хийгдээгүй байна.

2.1.1. Сэлэнгэ аймгийн ИТХ-ын 2023 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 128, 130, 131, 10 дугаар сарын 04-ний өдрийн 134, 135, 136, 137 дугаар тогтоолоор сум үүсгэн байгуулагдсаны 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэхийг зөвшөөрсөн бөгөөд уг тогтоолын 2-д “Ойгоо угтаж олон нийтийн идэвх санаачилгыг өрнүүлэн тодорхой бүтээлч ажил зохион байгуулж ажиллах”-ыг тус сумдын Засаг дарга нарт даалгасан байна.

2.1.2. 100 жилийн ойн арга хэмжээний хүрээнд Ерөө, Зүүнбүрэн, Мандал, Шаамар сумд нь бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын шинж чанартай дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:


Хүснэгт 5. Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажил

/Мянган төгрөгөөр/

№	Сумдын нэр	Хийгдсэн ТАХ-ний нэр	Мөнгөн дүн
1	Ерөө	Эко 00	21,000.0
		Угтах, үдэх хаалганы тохижилт	99,978.3
2	Зүүнбүрэн	Дурсгалын өндөрлөг хөшөө	103,000.0
3	Мандал	Нарийн гудамжны тохижилт	19,000.0
		Нийтийн эзэмшлийн зам, талбайн гэрэлтүүлэг, тохижилт	20,664.2
4	Шаамар	Цэнгэлдэх хүрээлэнгийн нойл	17,500.0
Нийт дүн			281,142.5



Ерөө суманд баригдсан нийтийн 00, угтах үдэх хаалганы тохижилт



Шаамар суманд баригдсан нийтийн 00



Мандал сумын “Нарийн гудамжны тохижилт”

2.1.3. Аудитын явцад хийсэн судалгаагаар хандивын эх үүсвэрээр ойн арга хэмжээнд нийт 4,477,132.2 мянган төгрөгийг зарцуулсан бөгөөд үүнээс 66.0 хувь буюу 2,953,400.0 мянган төгрөгийг хүлээн авалт, гарын бэлэг, бай шагналд, 13.9 хувь буюу 621,564.5 мянган төгрөгийг бүтээн байгуулалт, хөрөнгө бэлтгэхэд зарцуулсан байна.

2.1.4 Дээрхээс үзэхэд сум орон нутгийн иргэдэд ээлтэй, хүртээмжтэй, тодорхой үр дүнтэй ажил зохион байгуулалгүйгээр нэг удаагийн шинж чанартай арга хэмжээнд дийлэнх хувийг зарцуулсан байна.

2.1.5. Ойн арга хэмжээний хүрээнд төлөвлөсөн арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн эсэхийг газар дээр нь тулган баталгаажуулахад Баруунбүрэн, Ерөө, Зүүнбүрэн сумдын дараах арга хэмжээ дутуу хэрэгжсэн байна. Үүнд:

Баруунбүрэн сум:

- Тод гэгээн жим ХХК-тай баримтат кино хийлгэхээр 2024 оны 04 сарын 25-ны өдөр 18,000.0 мянган төгрөгийн гэрээ байгуулан, урьдчилгаа 10,500.0 мянган төгрөгийг шилжүүлсэн боловч баримтат кино одоог хүртэл хийгдээгүй,
- Үдшийн цэнгүүний арга хэмжээний хүрээнд дуучин Х.Мөнгөнцэцэгтэй 2024 оны 06 сарын 05-ны өдөр 70,000.0 мянган төгрөгийн гэрээ байгуулж, урьдчилгаа төлбөрт 40,000.0 мянган төгрөгийг шилжүүлэн үлдэгдэл 30,000.0 мянган төгрөгийг хувь хүнээс зээлж барагдуулсан байна.

Ерөө сум:

- Сумын 100 жилийн номын эх бэлтгэх ажлыг хийлгэхээр иргэн Л.Баяртулгаатай 2023 оны 12 дугаар сарын 12-ны өдөр 31,400.0 мянган төгрөгийн гэрээ байгуулан, 3 удаагийн санхүүжилтээр нийт 21,980.0 мянган төгрөгийг шилжүүлсэн бөгөөд номын эх бэлтгэлийг урьдчилсан байдлаар танилцуулахад шаардлага хангаагүй тул гэрээг 2025 оны 12 дугаар сарын 01-нийг хүртэл сунгасан боловч одоог хүртэл эх бэлтгэл бэлэн болоогүй,
- Номын эх бэлтгэл бэлэн болоогүй байхад “Нэпко” ХХК-тай 2024 оны 05 дугаар сарын 07-ны өдөр гэрээ байгуулан 120 нүүртэй 1000 ширхэг ном хэвлүүлэхээр 16,500.0 мянган төгрөгийн урьдчилгааг шилжүүлсэн байна.

Зүүнбүрэн сум:

- “Байгальжин Монументаль чимэглэлийн нийгэмлэг” ГҮТББ-тай сумын төвийн дурсгалын өндөрлөг, тэмдэг, медаль, дурсгалын баримал хийлгэхээр 2024 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр 202,320.0 мянган төгрөгийн гэрээ байгуулж 189,420.0 мянган төгрөгийг олгосон байна. Гэвч тус ГҮТББ нь гэрээнд заагдсан ажил болон төлбөрийн маргаантай байдлаас сумын төвд хийгдсэн “Дурсгалын өндөрлөг” ажлыг өнөөдрийг хүртэл хүлээлгэж өгөөгүй байна.



2.1.6. Зарим сумд нь хандивын орлогыг төлөвлөөгүй, тооцоо судалгааг бүрэн хийгээгүй, хийгдэж буй ажилд хяналт тавиагүй зэргээс шалтгаалж 5 арга хэмжээ бүрэн хэрэгжээгүй байна. Энэ нь нэг талаас хандивын хөрөнгө үнэгүйдэх, санхүүжилтийн эх үүсвэргүйн улмаас хөрөнгө оруулалтын шинж чанартай ажил бүрэн хэрэгжихгүй байх, нөгөө талаас сумын төсөвт дарамт үүсэх нөхцөл байдал бий болсон байна.

2.1.7. Иймээс дээрх сумд дуусаагүй арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэхэд үр дүнтэй ажил зохион байгуулах, эдгээр асуудалд сумын ИТХ, Засаг даргын зүгээс хяналт тавьж ажиллах шаардлагатай байна.

2.2 Ойн хандивын эх үүсвэрээр бий болсон хөрөнгийг бүртгэл тайланд бүрэн тусгасан уу?

Ойн хандивын хүрээнд бий болсон зарим хөрөнгийг бүртгэл тайланд тусгаагүй байна.

2.2.1. 2024 оны жилийн эцсийн байдлаар ой зохион байгуулсан 7 сум нь хандивын эх үүсвэрээр бэлтгэсэн болон хандиваар хүлээлгэн өгсөн нийт 558,299.8 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэл тайланд тусгасан байна. Үүнийг дараах хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 6. Бүртгэл тайланд тусгасан хөрөнгийн жагсаалт /Мянган төгрөгөөр/

№	Сумдын нэр	Үндсэн хөрөнгө				Нийт дүн	Бараа материал			Нийт орлогын дүн
		ЗДТГ	Соёлын төв	Цэцэрлэг	ЭМТ		ЗДТГ	Соёлын төв	Нийт үнэ	
1	Баруунбүрэн	206,789.6	9,630.0	1,839.6	26,200.0	244,459.2		34,806.8	34,806.8	279,266.0
2	Ерөө	39,543.4	33,553.0			73,096.4	32,148.0	33,740.5	65,888.5	138,984.9
3	Зүүнбүрэн	-	-	-	-	-	4,363.0	23,490.0	27,853.0	27,853.0
4	Мандал	-	-	-	-	-	-	-	-	-
5	Түшиг	-	-	-	-	-	-	-	-	-
6	Цагааннуур							8,410.0	8,410.0	8,410.0
7	Шаамар	67,626.0		2,780.0		70,406.0		33,380.0	33,380.0	103,786.0
	Нийт дүн	313,959.0	43,183.0	4,619.6	26,200.0	387,961.6	36,511.0	133,827.3	170,338.3	558,299.9

2.2.2. Харин дараах сумд нь нийт 590,423.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 55,745.0 мянган төгрөгийн бараа материалыг данс бүртгэлд тусгаагүй байна. /Дэлгэрэнгүйг хавсралт 2-т харуулав/ Үүнийг дараах хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 7. Бүртгэл тайланд тусгаагүй хөрөнгийн жагсаалт.

№	Сумдын нэр	Үндсэн хөрөнгө	Бараа материал	/Мянган төгрөгөөр/
				Нийт дүн
1	Баруунбүрэн	-	-	-
2	Ерөө	124,978.3	8,886.2	133,864.5
3	Зүүнбүрэн	152,000.0	-	152,000.0
4	Мандал	253,879.9	3,510.0	257,389.9
5	Түшиг	20,000.0	29,780.0	49,780.0
6	Цагааннуур	20,200.0	13,568.8	33,768.8
7	Шаамар	19,365.8	-	19,365.8
Нийт дүн		590,424.0	55,745.0	646,169.0

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2-т “Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэсэн заалтыг зөрчсөн байна.

2.2.3. Хандивын эх үүсвэрээр бэлтгэсэн хөрөнгийг бүртгэл тайланд тусгаагүй байгаа нь хөрөнгө эзэнгүйдэх, алдагдах эрсдэлийг дагуулж байна.

2.2.4. Иймд дээрх сумд нь бүртгэл тайланд тусгаагүй хөрөнгүүдийн саналыг холбогдох газарт хүргүүлж, шийдвэрлүүлэх шаардлагатай байна.

2.3 Сумдын ИТХ, Засаг даргын зүгээс хандивын зардлын гүйцэтгэлд хяналт хэрэгжүүлж, үр дүнг тооцож, иргэд олон нийтэд мэдээлсэн эсэх?

Хандивын хөрөнгийн зарцуулалтын үр дүнгийн талаарх мэдээллийг иргэд, олон нийтэд ил тод мэдээлээгүй байна.

2.3.1. Сумын 100 жилийн ойн арга хэмжээг зохион байгуулах “Ажлын хэсэг”-ийг Баруунбүрэн, Ерөө, Зүүнбүрэн, Мандал, Түшиг, Цагааннуур сумын ИТХ-ын тогтоолоор байгуулсан байна. Харин Шаамар сумын ойн арга хэмжээг зохион байгуулах “Ажлын хэсэг”-ийг сумын Засаг даргын захирамжаар байгуулсан байна.

2.3.2 Зүүнбүрэн, Түшиг, Шаамар сумын Засаг даргын 2024 оны А/64, А/69, А/84 дүгээр захирамжаар “Ажлын хэсэг”-ийн дарга болон сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга, ЗДТГ-ын дарга нарт 100 жилийн ойн арга хэмжээг эрчимжүүлэх, хяналт тавьж ажиллахыг үүрэг болгосон байна. Үүнийг дараах хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 8. Ажлын хэсэг байгуулсан сумдын ИТХ, Засаг даргын шийдвэр.

№	Байгууллагын төрөл	Ажлын хэсэг байгуулсан тогтоол, захирамж			
		ИТХ		Засаг дарга	
		Огноо	Дугаар	Огноо	Дугаар
1	Баруунбүрэн	2023.11.29	83	-	-
2	Ерөө	2024.01.09	120	-	-
3	Зүүнбүрэн	2024.02.02	9	2024.05.21	А/64
4	Мандал	2024.04.25	138	-	-

5	Түшиг	2023.05.02	78	2023.09.29	A/84
6	Цагааннуур	2024.06.03	126	-	-
7	Шаамар	-	-	2024.06.18	A/69

2.3.3. Цагааннуур, Түшиг, Шаамар сумдын НҮТББ-ын үйл ажиллагаанд ИТХ, Засаг даргын зүгээс хяналт огт хэрэгжүүлээгүй бол Баруунбүрэн, Ерөө, Зүүнбүрэн, Мандал сумын ИТХ-аас явцын хяналтыг дараах байдлаар хэрэгжүүлсэн байна. Тухайлбал:

- Ерөө сумын НҮТББ нь хяналтын зөвлөл байгуулж, явцын хяналтыг хэрэгжүүлсэн бөгөөд сумын ИТХ-ын ээлжит хуралдаанаар хандивын орлогын бүрдүүлэлт, зарцуулалтын явцын тайланг хэлэлцсэн,
- Баруунбүрэн, Зүүнбүрэн, Мандал сумын НҮТББ нь ойн хандивын орлогын бүрдүүлэлт, зарцуулалтын явцын тайланг сумын ИТХ-ын ээлжит хуралдаанаар 1-2 удаа хэлэлцсэн байна.

2.3.4. Дээрхээс үзэхэд 100 жилийн ойн хандивын орлогын бүрдүүлэлт, зарцуулалтын явцад хяналт хэрэгжүүлсэн боловч эцсийн үр дүнг үнэлж, дүгнэх ажил хийгдээгүй байна. Иймээс дээрх 7 сумын ИТХ, Засаг даргын зүгээс хандивын орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт хийж, үр дүнг үнэлж, дүгнэх шаардлагатай байна.

2.3.5. Төрийн бус байгууллагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5 дахь “Төрийн бус байгууллагын үйл ажиллагаа нь олон түмэнд ил тод байх ба түүний гишүүд болон иргэд хэн ч тухайн байгууллагын тайлантай танилцаж болно” гэж заасан байдаг.

2.3.6. Дээрх сумд нь хандивын орлогын бүрдүүлэлтийг тухай бүрд нь өөрсдийн цахим хаяг /Facebook/ -аар болон 100 жилийн ойд зориулсан сэтгүүлээр дамжуулан иргэд, олон нийтэд мэдээлэл хийсэн боловч хандивын зарцуулалтын гүйцэтгэлд Ерөө, Мандал, Цагааннуур сумаас бусад сумд иргэд, олон нийтэд ил тод мэдээлээгүй байна. Тухайлбал:

- Ерөө сум ойг зохион байгуулах ажлын хэсэг болон НҮТББ-ын зүгээс зардлын зарцуулалт гүйцэтгэлийн тайланг олон нийтэд танилцуулах зорилгоор иргэд, олон нийтийн төлөөллийг оролцуулан танхимын хэлэлцүүлэг зохион байгуулж, мэдээллийг ил тод хүргэсэн байна.
- Мандал, Цагааннуур сумдын 100 жилийн ой зохион байгуулах ажлын хэсэг нь үйл ажиллагааны тайлангаа мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор хэвлэмэл сэтгүүл болгон нийтэлж, орон нутгийн иргэд олон нийтэд түгээсэн байна.



Ойн хандив өгсөн иргэн, ААНБ-д “Талархал” илэрхийлж, нийтэд мэдээлсэн байна.



Ерөө сумын ажлын хэсэг, НҮТББ нь иргэдэд танхимаар мэдээлэл хийсэн байна.

2.3.7 Хандивын хөрөнгийн зарцуулалтын талаарх мэдээллийг Ерөө, Цагааннуур сумд нь иргэд, олон нийтэд ил тод мэдээлсэн бол бусад сумд мэдээлээгүй байна.

АУДИТААР ИЛРҮҮЛСЭН ЗӨРЧИЛ

Аудитаар нийт **738,049.0** мянган төгрөгийн зөрчил илэрч, 646,169.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 91,880.0 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөгдлөө. Үүнд:

- Ойн хандиваар бий болсон нийт 646,169.0 мянган төгрөгийн хөрөнгийг нягтлан бодох бүртгэл тайланд тусгаагүй,
- Баруунбүрэн, Ерөө, Зүүнбүрэн сумын ойн арга хэмжээний хүрээнд төлөвлөсөн нийт 91,880.0 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 5 арга хэмжээ бүрэн хэрэгжээгүй,
- Ойн хандивын орлогын бүрдүүлэлт, зарцуулалтын тайланг иргэд, олон нийтэд мэдээлээгүй, сумын ИТХ-аар хэлэлцүүлж, үр дүнг үнэлж, дүгнээгүй байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Ихэнх НҮТББ-ууд нь ойн хандивын орлогын төлөвлөгөөг сумын ИТХ-аар батлуулаагүй байна.
- Түшиг сумын “Зэлтэр сумын хөгжлийн сан” НҮТББ нь хандивын хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан байна.
- Иргэдэд ээлтэй, хүртээмжтэй, нөлөө үзүүлэхүйц үр дүнтэй ажил зохион байгуулаагүй, бүтээн байгуулалтын ажил хийгдээгүй байна.
- Ойн хандивын хүрээнд бий болсон зарим хөрөнгийг бүртгэл тайланд тусгаагүй байна.
- Хандивын хөрөнгийн зарцуулалтын үр дүнгийн талаарх мэдээллийг иргэд, олон нийтэд ил тод мэдээлээгүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад зөвлөж байна. Үүнд:

Сумдын ИТХ-ын дарга нарт:

- Сумын 100 жилийн ойн хүрээнд төлөвлөсөн арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэхэд анхаарч, ажлын гүйцэтгэл, үр дүнд хяналт тавьж ажиллах.
- Сумын 100 жилийн ойг зохион байгуулах үүрэгтэй байгуулагдсан төрийн бус байгууллагын хандивын орлогын бүрдүүлэлт, зарцуулалтын тайланг хэлэлцэж, үр дүнг тооцох, иргэд олон нийтэд бүрэн мэдээлэх.
- Хандивын орлогын зарцуулагдаагүй үлдэгдлийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх.

Шаамар сумын ИТХ-ын дарга Г.Отгонпүрэв-т :

- “Шаамарын хөгжил 100 жил” НҮТББ-ын хандивын орлогын бүрдүүлэлт, зарцуулалттай холбоотой асуудлыг холбогдох байгууллагаар шалгуулж, үр дүнг хэлэлцэн, иргэд олон нийтэд мэдээлэх.

Сумдын Засаг дарга нарт:

- Сумын 100 жилийн ойг зохион байгуулах үүрэгтэй байгуулагдсан төрийн бус байгууллагын хандивын орлогын бүрдүүлэлт, зарцуулалтын тайланг ИТХ-аар хэлэлцүүлэх.
- 100 жилийн ойн хандивын хүрээнд бий болсон хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

АХЛАХ АУДИТОР

АУДИТОР

АУДИТОР

АУДИТОР



Б.БАТМӨНХ

С.БААСАНСҮРЭН

Б.НАРАНЦЭЦЭГ

Ж.БАЯСГАЛАН

Р.ОТГОНЖАРГАЛ